

ХОЛБОО НАВИГАЦИ, АЖИГЛАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД
АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН
/ТОВЧЛОЛ/

2019.04.25

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2019 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Холбоо навигаци, ажиглалтын албаны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 19/05 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, менежер П.Батсайхан, аудитор П.Цогбаяр, А.Мөнх-Эрдэнэ, О.Сэндэр, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа, Ц.Цацрал, Ц.Оюут нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Холбоо навигаци, ажиглалтын албаны 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, анхан шатны баримт бүрдүүлэлт, худалдан авалт, цалин хөлсний борлолт, олголт, орлого хураалт, зардлын гүйцэтгэл зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

1. 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 89.6 оноогоор "В" буюу "Сайн" үнэлгээтэй дүгнэгдсэн байна.
2. Худалдан авалтын төлөвлөгөөнөөс хасагдсан, шинэ нисэх буудал ашиглалтад орох хугацаа хойшлогдсон, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэн зэрэгтэй холбогдуулан хэд хэдэн ажлыг дүгнэх боломжгүй болсон байна.
3. Ажилтнуудын хувийн хэргийн хөтлөлт, бүрдүүлэлт эмх цэгцтэй, ERP програмд хүний нөөцийн судалгааг сайн хийсэн.
4. Хүний нөөцийн судалгааны мэдээллийг Veriresh ERP програмд бүрэн оруулсан байна.
5. Захиргааны мэргэжилтэн ажлын цагийн бүртгэлийг буруу гаргадаг.
6. Захиргааны ахлах мэргэжилтний зүгээс тавих хяналт хангалтгүй. Хуулийн мэргэжилтэн ажлын байрны тодорхойлолтод тавигдсан чиг үүргийг хангалтгүй түвшинд гүйцэтгэж байна.
7. Чөлөө авсан ажилтнуудад хоолны мөнгө илүү олгосон.
8. Хортой нөхцөлд тодорхойлогдсон ажлын байранд ажиллаагүй ажилтнууд хортой нөхцөлийн нэмэгдэл авч байгаа нь буруу байна. Иймд ИНЕГ-ын даргын 2016 оны А/510 дугаар тушаалыг хүчингүй болгож ажлын байранд байнга ажиллаж байгаа ажилтнууд, зарим тохиолдолд ажиллаж байгаа ажилтнуудыг салгаж, тухайн тохиолдолд олгох эсэхийг тодорхой зааж өгөх шаардлагатай байна.
9. ХНАА-ны харьяа орон нутаг дахь өнгөрөлтийн цэг болон радиолокаторын байгууламжуудын харуул хамгаалалтын ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн гэрээний хугацаа 2016, 2017 онуудад дууссан боловч гэрээг үргэлжлүүлэн сунгасан байгаа нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 8 дугаар зүйл, Засгийн газрын 68 дугаар тогтоолоор баталсан босго үнийн шаардлагыг зөрчиж байна.
10. ИНЕГ-аас тавьж олгосон бичиг хэргийн материалыг зарцуулахдаа Сангийн сайдын 347 дугаар тушаалаар баталсан маягт зааврын дагуу агуулахын бүртгэлийг хийгээгүй.

ИНЕГ-ын даргын баталсан Нягтлан бодох бодлогын баримт бичиг болон холбогдох бусад журмын дагуу тус албаны бараа материал хариуцсан нягтлан бодогч нь бараа материалын няравыг хангалттай хэмжээний хяналт, чиг үүргээр хангаагүй байна.

11. Гадны байгууллагуудаас "Монголын цахилгаан холбоо" ХК-нд төлөх төлбөрийг ИНЕГ-аас тухай бүрт төлж барагдуулан дараа нь тухайн гадны байгууллагаас нэхэмжлэн авч байгаа нь ИНЕГ-ын эргэлтийн хөрөнгийн эргэцийг удаашруулахад нөлөөлж байна.
12. "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн гадны байгууллагуудаас авах телефон ярианы төлбөрийг ИНЕГ-ын ажилтан өмнөөс нь барагдуулж ажиллахтай холбогдон хүн хүч, цаг хугацааны нэмэлт үргүй зардал гарч байна.
13. Буянт-Ухаа спортын ордонтой 7 хоногт нэг удаа 17:00-19:00 цагийн хооронд спорт заалаар үйлчлэх, үйлчлүүлэх гэрээтэй боловч гэрээний хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаа талаар тодорхой бус, гэрээг дүгнээгүй.
14. ИНЕГ-ын гадны байгууллагуудтай байгуулсан телефон холбооны үйлчилгээ үзүүлэх гэрээнд хугацаа зааж өгөөгүй, ямар хугацаанд хүчин төгөлдөр байх нь тодорхойгүй, олон жил дамжин явж ирсэн.
15. Телефон холбооны үйлчилгээ үзүүлэх гэрээнд үйлчилгээний төлбөр авах талаар гэрээний хоёрдугаар бүлэгт бүхэлд нь заасан боловч ИНЕГ нь үйлчилгээний төлбөр авах эрх зүйн үндэслэл нь тодорхойгүй, үйлчилгээний үнэ тариф байхгүйгээс дотоод холбоогоор үйлчилсний төлбөр авдаггүй.
16. Эзэмших утасны дугаарууд гэрээнд зааснаас өөрчлөгдсөн байхад гэрээнд өөрчлөлт оруулаагүй. Зарим байгууллагад тавигдсан телефон утас ашиглагдаагүй байна.
17. Гадны байгууллагуудаас "Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д төлөх цахилгаан, эрчим хүчний төлбөрийг ИНЕГ-аас тухай бүрт төлж барагдуулан дараа нь тухайн гадны байгууллагаас нэхэмжлэн авч байгаа нь ИНЕГ-ын эргэлтийн хөрөнгийн эргэцийг удаашруулахад нөлөөлж байна.
18. "Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн гадны байгууллагуудаас авах цахилгаан эрчим хүчний төлбөрийг барагдуулах ажлыг ИНЕГ-ын ажилтан хариуцан ажиллаж байгаатай холбогдон хүн хүч, цаг хугацааны нэмэлт үргүй зардал гарч байна.
19. ИНЕГ-ын харьяа алба, нэгжүүдийн цахилгаан эрчим хүчний цахилгаан эрчим хүчний сарын зарцуулалт маш их зөрүүтэй байгаа нь харьяа алба, нэгжүүдийн цахилгаан эрчим хүчний зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.
20. ИНЕГ-ын харьяаны бус гадны байгууллагуудтай байгуулсан цахилгаан эрчим хүчээр хангах, хэрэглэх гэрээнүүдийн хугацаа дуусаад 10 гаруй жил өнгөрсөн.
21. Цахилгааны үнэ тариф, төлбөр тооцоо хийх журмын талаар гэрээний Дөрөвдүгээр бүлэгт бүхэлд нь заасан боловч ИНЕГ нь үйлчилгээний төлбөр авах эрх зүйн үндэслэл нь тодорхойгүй, үйлчилгээний үнэ тариф байхгүй. Үүний улмаас цахилгаан эрчим хүчээр үйлчилсний төлбөр огт авдаггүй байна.
22. Овоот болон Ханбумбат нисэх буудалд ажиллаж байгаа инженер, техникийн ажилтнуудын цалингийн зардал нь "Эй Си Эйч Сервисес" ХХК, "Саусгоби сэндрс" ХХК-уудтай хамтран ажиллах гэрээнд заасан үйлчилгээний орлогоос их байгаа нь байгууллагын хувьд алдагдалтай гэрээ болсон байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар мэргэжлийн нэгж болон тус албанд нийт 15 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА